ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 23 өдөр Дугаар А/648 Арвайхээр

## Улсын үзлэг тооллого зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5.а, 29.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэр дээрх түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг тооллого зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, уг ажилд шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Улсын тооллогод шаардагдах 1,980,000 (нэг сая есөн зуун наян мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

3.Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг хууль тогтоомжид нийцүүлэн үр дүнтэй зохион байгуулж тайлагнахыг ажлын хэсэг (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

4.Улсын үзлэг тооллогыг орон нутагт хамтран зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

011101379

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны..12..
дугаар сарын ..23..-ны өдрийн..А/648..
дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

# УЛСЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗАРДАЛ

| № | Зардлын төрөл | Нэг бүрийн үнэ | Тоо хэмжээ | Нийт | Зардлын хуваарилалт | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бензин | 2400 | 810 л | 1886750 | 3,500,000 | Соёл урлагийн газраас |
| 2 | Масло | 15000 | 6 | 89250 | | |
| 3 | тосол | 6000 | | 84000 | | |
| 4 | Томилолт | 12000 | 8хүн 15 хоног | 1440000 | | |
| 5 | Томилолт | 12000 | 8 хүн 6 хоног | 672,000 | 1,980,000 | Аймгийн Засаг даргын Тамгын газраас |
| 6 | Бичиг хэргийн зардал (цаас,үзэг, харандаа, хэмжих метр, шугам, маркер, самбар, гэрэл ойлгогч, шохой, фото цаас) | | | 308,000 | | |
| 7 | Автомашины хөлс | | | 1000,000 | | |
| | | | Нийт | | 5,480,000 | |

-oOo-

Аймгийн Засаг даргын 2021 оны...12...
дугаар сарын ...23....-ны өдрийн...А/648...
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

# УЛСЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Л.Пүрэвлхам (Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газрын Соёл, урлагийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга Н.Гантулга (Аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санч)

Гишүүд: Д.Тогтох (Аймгийн музейн захирал)

Д.Одонбаяр (Аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа)

Ц.Энхцэцэг (Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Г.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн хэлтсийн мэргэжилтэн)

А.Мөнх-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын  соёл, урлагийн хяналтын улсын байцаагч)

П.Баянсан (Хархорин музейн эрдэм шинжилгээний ажилтан археологич)

Ж.Цамбагарав (Хархорин музейн эрдэм шинжилгээний ажилтан археологич)

-oOo-